XXYII.2.2.1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны засвар /Архангай/	2013	2013	245.1	245.1
XXYII.2.2.2	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байрны засвар /Баян-Өлгий/	2013	2013	70.0	70.0
XXYII.2.2.3	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дадлагын байрны засвар /Дундговь/	2013	2013	175.0	175.0
XXYII.2.2.4	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дадлагын байрны засвар /Завхан/	2013	2013	176.2	176.2
XXYII.2.2.5	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байрны засвар /Сэлэнгэ, Шаамар/	2013	2013	91.6	91.6
XXYII.2.2.6	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байрны засвар /Төв, Заамар/	2013	2013	56.2	56.2
XXYII.2.2.7	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн болон дотуур байрны дээврийн засвар /Дархан-Уул/	2013	2013	68.4	68.4
XXYII.2.2.8	"Дархан өргөө" мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн болон дадлагын байрны засвар /Дархан-Уул/	2013	2013	68.1	68.1
XXYII.2.2.9	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн болон дадлагын байрны засвар /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2013	2013	151.7	151.7
XXYII.2.2.10	Үйлдвэр урлалын сургуулийн хичээлийн байрны засвар /Улаанбаатар/	2013	2013	20.0	20.0
XXYII.2.2.11	Коллежийн дотуур байрны засвар /Увс, Улаангом/	2013	2013	98.1	98.1
XXYII.2.3	Тоног төхөөрөмж:			12,036.5	3,500.0
XXYII.2.3.1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн тоног төхөөрөмж	2013	2015	12,036.5	3,500.0
XXYII.2.4	Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл:			79.5	79.5
XXYII.2.4.1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл	2013	2013	79.5	79.5
<b>XXYII.3</b>	<b>Хөдөлмөрийн яам</b>			<b>4,453.8</b>	<b>3,983.8</b>
XXYII.3.1	Их засвар:			250.0	250.0
XXYII.3.1.1	Хөдөлмөрийн нөхцөл мэргэжлийн өвчин судлалын үндэсний төв /Улаанбаатар/	2013	2013	250.0	250.0
XXYII.3.2	Тоног төхөөрөмж:			4,203.8	3,733.8
XXYII.3.2.1	Хөдөлмөрийн институт, Солонгос дахь Хөдөлмөрийн алба	2013	2015	770.0	450.0
XXYII.3.2.2	Хөдөлмөрийн яам автомашин	2013	2013	163.8	163.8
XXYII.3.2.3	Компьютер, тоног төхөөрөмж	2013	2013	3,000.0	3,000.0
XXYII.3.2.4	Хөдөлмөрийн нөхцөл мэргэжлийн өвчин судлалын үндэсний төв /Улаанбаатар/	2013	2014	270.0	120.0
<b>XXYIII</b>	<b>ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД</b>			<b>160,489.0</b>	<b>77,737.6</b>
XXYIII.1	Хөрөнгө оруулалт:			86,812.2	30,053.0
	Шилжих:			81,922.2	25,163.0
XXYIII.1.1	Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөдөөгийн амьжиргаа" төслийн дотоод эх үүсвэр	2012	2016	3,917.2	100.0
XXYIII.1.2	Хүнсний лабораторий байгуулах /Улаанбаатар/	2012	2013	4,300.0	3,138.0

ХХҮIII.1.3	Хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах /Бүх аймагт/	2011	2015	26,584.0	7,000.0
ХХҮIII.1.4	Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2012	2013	650.0	425.0
ХХҮIII.1.5	Малын удмын сангийн үндэсний цогцолбор /Дархан-Уул, Хонгор/	2012	2015	12,271.0	5,500.0
ХХҮIII.1.6	Түүхий эд, бүтээгдэхүүний бирж байгуулах, түүхий эдийн агуулах байгуулах /Улаанбаатар, бүх аймгууд/	2012	2013	5,000.0	5,000.0
ХХҮIII.1.7	Бэлчээр усжуулах зорилгоор гүний өрмийн худагт салхин сэнсэн шахуурга суурилуулах /Дорноговь, Говьсүмбэр/	2012	2013	200.0	200.0
ХХҮIII.1.8	Хилийн боомтуудад ариутгал халдваргүйтлийн байгууламж байгуулах (Монгол мал үндэсний хөтөлбөр)	2012	2017	29,000.0	3,800.0
	Шинэ:			4,890.0	4,890.0
ХХҮIII.1.9	Буянт голын усалтын систем /Ховд/	2013	2013	2,000.0	2,000.0
ХХҮIII.1.10	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд/	2013	2013	2,000.0	2,000.0
ХХҮIII.1.11	Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын барилга /Сүхбаатар, Баруун-Урт/	2013	2013	890.0	890.0
ХХҮIII.2	Их засвар:			1,998.8	1,520.6
ХХҮIII.2.1	Мал эмнэлгийн лабораторийн засвар /Булган, Өвөрхангай/	2013	2013	55.0	55.0
ХХҮIII.2.2	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын засвар /Говь-Алтай, Дорнод/	2013	2013	30.4	30.4
ХХҮIII.2.3	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын засвар /Дорноговь/	2011	2013	99.8	54.8
ХХҮIII.2.4	Мал эмнэлгийн лабораторийн засвар /Дундговь/	2011	2013	178.0	170.0
ХХҮIII.2.5	Мал эмнэлгийн лабораторийн засвар /Завхан/	2011	2013	370.9	288.6
ХХҮIII.2.6	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар болон Мал эмнэлгийн лабораторийн засвар /Өмнөговь/	2013	2013	157.9	157.9
ХХҮIII.2.7	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны 250 хүний суудалтай хурлын заалны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2013	445.0	445.0
ХХҮIII.2.8	Мал эмнэлгийн лабораторийн засвар /Сүхбаатар/	2011	2013	63.7	25.0
ХХҮIII.2.9	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын засвар /Төв, Говьсүмбэр/	2013	2013	13.1	13.1
ХХҮIII.2.10	Мал эмнэлгийн лабораторийн барилгын их засвар /Хэнтий/	2013	2013	50.0	50.0
ХХҮIII.2.11	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын их засвар /Дархан-Уул/	2011	2013	185.0	150.0
ХХҮIII.2.12	Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын төв /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2012	2013	350.0	80.8
ХХҮIII.3	Тонго төхөөрөмж:			3,819.0	2,554.0
ХХҮIII.3.1	Мал эмнэлгийн ариутгал халдваргүйтлийн арга хэмжээг хэрэгжүүлэх, өвчтэй малыг халдвар дамжуулахгүйгээр нядлах тоног төхөөрөмж /Монгол мал үндэсний хөтөлбөр/	2011	2013	1,200.0	1,200.0
ХХҮIII.3.2	Хөнгөн үйлдвэрийн салбарт нано биотехнологи нутагшуулах	2012	2013	500.0	250.0
ХХҮIII.3.3	Үйлдвэр, хөдөө аж ахуйн байгууллагуудын тоног, төхөөрөмжийн шинэчлэл	2012	2013	2,030.0	1,015.0
ХХҮIII.3.4	Төрийн өмчийн хорооны тоног төхөөрөмж	2013	2013	89.0	89.0
ХХҮIII.4	Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл:			15,410.0	15,410.0
ХХҮIII.4.1	Аймгийн мал эмнэлгийн барилга шинээр барих техник эдийн засгийн үндэслэл боловсруулах /Баянхонгор/	2013	2013	20.0	20.0



XXYIII.4.2	Үйлдвэр технологийн парк байгуулах судалгаа, зураг төсөл, био-технологийн лабораторийг чадавхижуулах, Нано технологийн төв болон лаборатори байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах	2013	2013	590.0	590.0
XXYIII.4.3	Нийслэл хотод хоногт 5-аас доошгүй тн сүү хүлээн авч нярай хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах /Улаанбаатар/	2013	2013	50.0	50.0
XXYIII.4.4	Загасны үйлдвэр байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах /Завхан, Архангай, Говь-Алтай, Ховд, Хөвсгөл/	2013	2013	50.0	50.0
XXYIII.4.5	Таримал ургамлын элит үр үржүүлэг, шинэ сортыг бий болгох, нутагшуулах, сорт сорилт, судалгааны ажлыг эрчимжүүлж, үрийн чанар хангамжийг сайжруулах;	2013	2013	3,000.0	3,000.0
XXYIII.4.6	Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангах, нүүрснээс шингэн түлш, хий гаргах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах	2013	2013	2,900.0	2,900.0
XXYIII.4.7	Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор болон Багануур, Дарханы үйлдвэр технологийн паркийн захиргаа байгуулах, ерөнхий төлөвлөгөө боловсруулах /Дорноговь, Улаанбаатар, Дархан-Уул/	2013	2013	8,700.0	8,700.0
XXYIII.4.8	Зүүн бүсийн холимог металлын ордын түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулах судалгаа	2013	2013	100.0	100.0
XXYIII.5	Хөрөнгийн шилжүүлэг, дэмжлэг			52,449.0	28,200.0
XXYIII.5.1	Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах байгуулах /Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Булган, Улаанбаатар, Увс, Хөвсгөл, Дорнод/	2012	2013	20,500.0	10,500.0
XXYIII.5.2	Усгалтын системийг сэргээн засварлах, шинээр барих /Зураг төсөв нь хийгдсэн усалгаатай тариалан эрхлэх боломжтой бүс нутаг/	2012	2013	6,800.0	6,800.0
XXYIII.5.3	Өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх /Дархан-Уул, Орхон, Улаанбаатар/	2011	2013	3,000.0	1,000.0
XXYIII.5.4	Сум дундын загвар нядалгааны цех байгуулахад дэмжлэг үзүүлэх	2013	2013	400.0	400.0
XXYIII.5.5	Төмс, хүнсний ногоо, тариалангийн техникийн шинэчлэл	2012	2013	7,000.0	6,000.0
XXYIII.5.6	Хүнсний ногооны хүлэмжийн аж ахуй байгуулах	2012	2013	1,000.0	1,000.0
XXYIII.5.7	Малын тэжээлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж (Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй аймаг, сум, хот суурин газрууд)	2012	2017	13,749.0	2,500.0
<b>XXIX</b>	<b>БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙД</b>			<b>29,951.2</b>	<b>10,185.2</b>
<b>XXIX.1</b>	<b>Хөрөнгө оруулалт:</b>			<b>24,355.0</b>	<b>6,639.0</b>
	Шилжих:			15,985.0	3,889.0
XXIX.1.1	Газар доорхи цэвдгийн хяналтын цооног өрөмдөж тоноглох	2012	2013	200.0	50.0
XXIX.1.2	Газар доорхи усны хяналт шинжилгээний хяналтын цооног өрөмдөж тоноглох	2012	2013	1,345.0	480.0
XXIX.1.3	Ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуул /Улаанбаатар хотын шинэ суурьшлын бүс/	2012	2013	670.0	168.0
XXIX.1.4	Нислэгийн цаг уурын төвийн барилга	2012	2013	290.0	73.0
XXIX.1.5	Сумдын цаг уурын шинжилгээний өртөөний барилга /Дорнод, Сүмбэр/	2012	2013	50.0	31.3
XXIX.1.6	Сумдын цаг уурын шинжилгээний өртөөний барилга /Өвөрхангай, Баян-Өндөр/	2012	2013	50.0	31.3
XXIX.1.7	Сумдын цаг уурын шинжилгээний өртөөний барилга /Дундговь, Эрдэнэдалай./	2012	2013	50.0	31.3



XXIX.1.8	Сумдын цаг уурын шинжилгээний өртөөний барилга /Төв, Угтаал/	2012	2013	50.0	31.3
XXIX.1.9	Сумдын цаг уурын шинжилгээний өртөөний барилга /Төв, Алтанбулаг/	2012	2013	50.0	31.3
XXIX.1.10	Сумдын цаг уурын шинжилгээний өртөөний барилга /Говь-Алтай, Хөхморьт/	2012	2013	50.0	31.3
XXIX.1.11	Сумдын цаг уурын шинжилгээний өртөөний барилга /Говь-Алтай, Тонхил/	2012	2013	50.0	31.3
XXIX.1.12	Сумдын цаг уурын шинжилгээний өртөөний барилга /Завхан, Завханмандал/	2012	2013	50.0	31.3
XXIX.1.13	Сумдын цаг уурын шинжилгээний өртөөний барилга /Увс, Тас/	2012	2013	50.0	31.3
XXIX.1.14	Сумдын цаг уурын шинжилгээний өртөөний барилга /Сүхбаатар, Эрдэнэцагаан/	2012	2013	50.0	31.3
XXIX.1.15	Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны барилгын дутуу /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2012	2013	100.0	100.0
XXIX.1.16	Гадаргын усны хяналт, шинжилгээний сүлжээг өргөтгөх, мэдээллийн сан үүсгэх	2012	2013	580.0	355.0
XXIX.1.17	Уул уурхайн ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажил /Тавантолгойн нүүрсний уурхайн усан хангамж/	2012	2013	800.0	600.0
XXIX.1.18	Зүүн бүсийн газрын доорх усны нөөцийн үйлдвэрлэлийн судалгаа /Сайншандын аж үйлдвэрийн паркийн усан хангамж, Дорноговь/	2012	2014	1,500.0	550.0
XXIX.1.19	Хог боловсруулах үйлдвэр /Улаанбаатар/	2012	2014	10,000.0	1,200.0
	Шинэ:			8,370.0	2,750.0
XXIX.1.20	Газрын генератор болон дагалдах бусад тоног төхөөрөмж худалдан авч суурилуулах	2013	2015	750.0	200.0
XXIX.1.21	Ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуул	2013	2015	2,500.0	500.0
XXIX.1.22	Газар доорх усны хэмжилтийн цэг цооног байгуулж, автомат багажаар тоноглох	2013	2015	2,270.0	500.0
XXIX.1.23	Байгалийн ургамлын генобанк байгуулах	2013	2015	1,900.0	600.0
XXIX.1.24	Хамгаалалтын захиргааны конторын барилга /Зэд Хантайн Бүтээлийн нурууны Дархан цаазат газар/	2013	2013	200.0	200.0
XXIX.1.25	Хамгаалалтын захиргааны конторын барилга /Хан Хөхий нурууны улсын тусгай хамгаалалттай газар/	2013	2013	200.0	200.0
XXIX.1.26	Хамгаалалтын захиргааны конторын барилга /Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газар/	2013	2013	200.0	200.0
XXIX.1.27	Хамгаалалтын захиргааны конторын барилга /Их газрын чулууны Байгалийн цогцолборт газар/	2013	2013	200.0	200.0
XXIX.1.28	Байгаль хамгаалагчийн нэг загварын байр /Увс нуурын улсын тусгай хамгаалалттай газар, Орхоны хөндийн байгалийн цогцолборт газар, Хөвсгөлийн байгалийн цогцолборт газар, Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газар, Монгол Элсний байгалийн цогцолборт газар, Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газар, Хан хөхий хяргас нуурын байгалийн цогцолборт газар, Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газар, Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газар, Их газрын чулууны байгалийн цогцолборт газар/	2013	2013	150.0	150.0
XXIX.2	Их засвар:			513.2	513.2
XXIX.2.1	Байгаль орчин, ногоон хөгжлийн салбарын засвар	2013	2013	513.2	513.2
XXIX.3	Тоног төхөөрөмж:			5,083.0	3,033.0
XXIX.3.1	Цаг уурын шинжилгээний өртөөдөд цаг уурын автомат станц суурилуулах	2013	2014	1,567.1	667.1



XXIX.3.2	Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораторийн цахилгааны эх үүсвэрийг сайжруулах "Цахилгааны дэд станц" шинээр барьж тоноглох	2013	2013	312.9	312.9
XXIX.3.3	Гүний усны хүнд металын бохирдлын түвшинг тодорхойлох зөөврийн лаборатори	2013	2013	80.0	80.0
XXIX.3.4	Салбарын байгууллагуудын автомашины парк шинэчлэл	2013	2013	300.0	300.0
XXIX.3.5	Байгаль хамгаалагчийн мотоцикл	2013	2013	100.0	100.0
XXIX.3.6	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, салбарын байгууллагуудын материаллаг бааз техник хэрэгсэл, тоног төхөөрөмж	2013	2014	2,000.0	850.0
XXIX.3.7	Шинээр байгуулагдсан цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн албан хэрэгцээний техник хэрэгсэл, тоног төхөөрөмж	2013	2013	120.0	120.0
XXIX.3.8	Мод бэлтгэл, тээвэрлэлт, борлуулалтыг хянах, хяналтын видео систем	2013	2013	130.0	130.0
XXIX.3.9	Холбооны хэрэгсэл	2013	2013	73.0	73.0
XXIX.3.10	Диоксин, фураны дээж авах, шинжилгээ хийх лаборатори	2013	2013	400.0	400.0
<b>XXX</b>	<b>БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД</b>			<b>55,169.2</b>	<b>21,939.1</b>
<b>XXX.1</b>	<b>Хөрөнгө оруулалт:</b>			<b>55,169.2</b>	<b>21,939.1</b>
XXX.1.1	Цэргийн эмнэлгийн төв цогцолбор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2011	2013	17,478.8	4,376.5
XXX.1.2	Энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх	2012	2013	4,213.4	3,568.4
XXX.1.3	Батлан хамгаалах салбарын сувиллын цогцолборын барилга /Хэнтий, Дэлгэрхаан/	2012	2013	851.0	461.0
XXX.1.4	Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн барилга /Хэнтий, Дэлгэрхаан/	2012	2013	270.0	68.0
XXX.1.5	Барилга, инженерийн батальоны барилга байгууламж /Сүхбаатар, Баруун-Урт/	2012	2013	1,400.0	350.0
XXX.1.6	Батлан хамгаалах яамны харьяа "Бага баян" төрийн өмчит үйлдвэрийн газрын амралтын газрын авто замын шинэчлэл /Улаанбаатар/	2012	2013	1,750.0	1,015.0
XXX.1.7	Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2013	530.7	530.7
XXX.1.8	Цэргийн албан хаагчдын албан тушаалын 63 айлын орон сууц /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2013	2,773.0	2,773.0
XXX.1.9	Цэргийн албан хаагчдын албан тушаалын 16 айлын орон сууц /Хэнтий, Дэлгэрхаан/	2013	2013	340.0	340.0
XXX.1.10	Цэргийн албан хаагчдын албан тушаалын 8 айлын орон сууц /Баян-Өлгий, Өлгий/	2013	2013	128.0	128.0
XXX.1.11	"Тэмүүжин-Өрлөг" төслийн Ерөнхий боловсролын сургуулийн цогцолбор төвийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2012	2013	5,256.5	2,856.5
XXX.1.12	Батлан хамгаалах их сургуулийн "Биеийн тамирын цогцолбор"-ын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2014	6,213.9	1,200.0
XXX.1.13	Говийн бүсийн сургалтын төв төсөл /Өмнөговь, Даланзадгад/	2013	2014	7,500.0	2,500.0
XXX.1.14	"Шонхор хүүхдийн зуслан" төслийн соёлын төв, халуун ус /Сэлэнгэ, Мандал/	2013	2013	250.0	250.0
XXX.1.15	"Цэрэг спортын төв цогцолбор" төсөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Алдар спорт хороо/	2013	2015	6,213.9	1,522.0
<b>XXXI</b>	<b>ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА</b>			<b>22,619.3</b>	<b>22,619.3</b>
XXXI.1	Хөрөнгө оруулалт:			18,713.8	18,713.8
	Шинэ:			18,713.8	18,713.8
XXXI.1.1	Аймгийн шүүхийн албан конторын барилга шинээр барих /Дархан-Уул, Дархан/	2013	2013	1,268.3	1,268.3
XXXI.1.2	Аймгийн шүүхийн албан конторын барилгын өргөтгөлийн ажил /Говьсүмбэр/	2013	2013	402.5	402.5



XXXI.1.3	Шүүгчдийн албан тушаалын орон сууц	2013	2013	2,043.0	2,043.0
XXXI.1.4	Шүүхийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2013	7,500.0	7,500.0
XXXI.1.5	Шүүхийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2013	2013	7,500.0	7,500.0
XXXI.2	Тоног төхөөрөмж:			3,409.8	3,409.8
XXXI.2.1	Аймаг, нийслэлийн шүүхүүдэд тоног төхөөрөмж худалдан авах	2012	2013	3,409.8	3,409.8
XXXI.3	Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл:			495.7	495.7
<b>XXXII</b>	<b>УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ</b>			<b>10,792.0</b>	<b>5,792.0</b>
XXXII.1	Хөрөнгө оруулалт:			10,000.0	5,000.0
XXXII.1.1	Улсын дээд шүүх болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2013	2014	10,000.0	5,000.0
XXXII.2	Их засвар:	2013	2013	63.0	63.0
XXXII.3	Тоног төхөөрөмж:			549.0	549.0
XXXII.3.1	Компьютер, техник хэрэгсэл	2013	2013	123.0	123.0
XXXII.3.2	Тээврийн хэрэгсэл	2013	2013	240.0	240.0
XXXII.3.3	Тавилга, эд хогшил	2013	2013	186.0	186.0
XXXII.4	Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл:	2013	2013	180.0	180.0
<b>XXXIII</b>	<b>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА</b>			<b>3,001.4</b>	<b>3,001.4</b>
XXXIII.1	Хөрөнгө оруулалт:			2,000.0	2,000.0
XXXIII.1.1	Албан тушаалын орон сууц /Улаанбаатар/	2013	2013	2,000.0	2,000.0
XXXIII.2	Их засвар:			180.0	180.0
XXXIII.2.1	Авлигатай тэмцэх газрын барилгын их засвар	2013	2013	180.0	180.0
XXXIII.3	Тоног төхөөрөмж:			821.4	821.4
XXXIII.3.1	Компьютер, техник хэрэгсэл	2013	2013	155.2	155.2
XXXIII.3.2	Тавилга, эд хогшил	2013	2013	113.2	113.2
XXXIII.3.3	Машин, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын техник хэрэгсэл	2013	2013	553.0	553.0
<b>XXXIV</b>	<b>УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР</b>			<b>23,341.6</b>	<b>20,282.0</b>
XXXIV.1	Хөрөнгө оруулалт:			20,562.2	18,112.2
	Шилжих:			1,662.2	512.2
XXXIV.1.1	Сум дундын прокурорын газрын конторын барилга /Дорноговь, Замын-Үүд/	2012	2013	850.0	400.0
XXXIV.1.2	Аймгийн прокурорын газрын конторын барилга /Дархан-Уул/	2012	2013	812.2	112.2
	Шинэ:			18,900.0	17,600.0
XXXIV.1.3	Улсын ерөнхий прокурорын газрын албаны орон сууц	2013	2014	2,500.0	1,200.0
XXXIV.1.4	Прокурорын байгууллагын ажилчдын орон сууцны барилга /Улаанбаатар/	2013	2013	2,500.0	2,500.0
XXXIV.1.5	Аймгийн прокурорын газрын конторын барилга /Дундговь/	2013	2013	1,000.0	1,000.0
XXXIV.1.6	Аймгийн прокурорын газрын конторын барилга /Сэлэнгэ/	2013	2013	1,000.0	1,000.0
XXXIV.1.7	Аймгийн прокурорын газрын конторын барилга /Баян-Өлгий/	2013	2013	1,000.0	1,000.0
XXXIV.1.8	Сум дундын прокурорын газрын конторын барилга /Завхан, Тосонцэнгэл/	2013	2013	450.0	450.0
XXXIV.1.9	Сум дундын прокурорын газрын конторын барилга /Ховд, Булган/	2013	2013	450.0	450.0
XXXIV.1.10	Прокурорын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2013	5,000.0	5,000.0
XXXIV.1.11	Прокурорын барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2013	2013	5,000.0	5,000.0
XXXIV.2	Их засвар:			1,450.0	1,450.0
XXXIV.2.1	Улсын ерөнхий прокурорын газрын сургалтын төвийн засвар /Улаанбаатар/	2013	2013	1,210.0	1,210.0
XXXIV.2.2	Сум дундын прокурорын газрын конторын барилгын их засвар /Өвөрхангай, Хархорин/	2013	2013	120.0	120.0
XXXIV.2.3	Сум дундын прокурорын газрын конторын барилгын их засвар /Хэнтий, Бор-Өндөр/	2013	2013	120.0	120.0



XXXIY.3	Тоног төхөөрөмж:			1,329.4	719.8
XXXIY.3.1	Сүлжээний дэд бүтэц байгуулах	2012	2013	732.6	123.0
XXXIY.3.2	Компьютер, тоног төхөөрөмж	2013	2013	160.8	160.8
XXXIY.3.3	Тавилга, эд хогшил	2013	2013	436.0	436.0
<b>НИЙТ ДҮН</b>				<b>3,189,107.3</b>	<b>1,550,249.2</b>

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 11 дүгээр  
сарын 08-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2013 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2013 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль<sup>1</sup>, Төсвийн тогтвортой байдлын тухай<sup>2</sup>, Нийгмийн даатгалын тухай хууль<sup>3</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2013 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын санд 2013 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

<sup>1</sup>Төсвийн тухай хууль-"Төрийн мэдээлэл"эмхтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Төсвийн тогтвортой байдлын тухай хууль-"Төрийн мэдээлэл"эмхтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Нийгмийн даатгалын тухай хууль-"Төрийн мэдээлэл"эмхтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.



д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	875,340.2
	1.1.аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	313,767.3
	1.2.ажиллагсдаас төлөх шимтгэл	382,529.7
	1.3.төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	131,164.4
	1.4.нөхөн олговор авагчийн нийгмийн даатгалын шимтгэл	6.2
	1.5.Хүний хөгжил сангаас төлөх иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэл	12,151.5
	1.6.сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	14,285.8
	1.7.эрүүл мэндийн даатгалын бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	2,167.3
	1.8.гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	1,400.0
	1.9.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	779.5
	1.10.бусад орлого	17,088.5
2	Сангийн сайд	294,279.4
	2.1.улсын төсвөөс олгох татаас, шилжүүлэг	294,279.4
<b>Нийт орлого</b>		<b>1,169,619.6</b>

**4 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	
	1.1.Тэтгэврийн даатгалын сан	813,795.0
	1.2.Тэтгэмжийн даатгалын сан	54,354.3
	1.3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	31,795.2
	1.4.Ажилгүйдлийн даатгалын сан	11,275.0
	1.5.Эрүүл мэндийн даатгалын сан	131,721.5
	1.6.Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны төлбөр	108.1
	1.7.үйл ажиллагааны урсгал зардал	18,376.8
	1.8.хөрөнгийн зардал	5,383.0
<b>Нийт зарлага</b>		<b>1,066,808.9</b>

### ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

**5 дугаар зүйл.** “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



Нийгмийн даатгалын сангийн 2013 оны  
төсвийн тухай хуулийн хавсралт

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР  
2013 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,  
АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

/сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүч чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2013 онд санхүүжих
	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР</b>		<b>7474.5</b>	<b>5383.0</b>
<b>1</b>	<b>Хөрөнгө оруулалт:</b>		<b>5298.8</b>	<b>3298.8</b>
1.1	Нийгмийн даатгалын салбарын "Цахим төрөлжсөн архив"-ын барилгыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын салбарын мэдээллийн төвтэй цогцоор барих /Улаанбаатар/	2012-2013	4161.3	2161.3
1.2	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2012-2013	50.9	50.9
1.3	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2013	116.0	116.0
1.4	Нийгмийн даатгалын тасгийн барилга /Өмнөговь, Цогтцэций/	2013	455.5	455.5
1.5	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр/	2013	515.1	515.1
<b>2</b>	<b>Их засвар:</b>		<b>831.3</b>	<b>831.3</b>
2.1	Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн их засвар /Баян-Өлгий/	2013	25.1	25.1
2.2	Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн их засвар /Говь-Алтай/	2013	17.8	17.8
2.3	Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн их засвар /Дундговь/	2013	37.7	37.7
2.4	Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн их засвар /Дорнод/	2013	113.7	113.7
2.5	Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн их засвар /Сэлэнгэ, Сайхан/	2013	10.3	10.3
2.6	Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн их засвар /Төв/	2013	351.0	351.0
2.7	Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн их засвар /Ховд/	2013	30.0	30.0
2.8	Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн их засвар /Дархан-Уул/	2013	65.0	65.0
2.9	Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн их засвар /Улаанбаатар, Нийгмийн даатгалын ерөнхий газар/	2013	67.4	67.4
2.10	Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн их засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2013	22.8	22.8
2.11	Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2013	41.0	41.0



2.12	Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн их засвар /Хэнтий/	2013	21.0	21.0
2.13	Гадна талбай орчны тохижилт, хайс хашаа барих, шинэчлэх /Увс, Багануур, Налайх/	2013	23.5	23.5
2.14	Төмөр хашаа барих, явган хүний зам тавих /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2013	5.0	5.0
<b>3</b>	<b>Тоног төхөөрөмж:</b>		<b>1260.6</b>	<b>1169.1</b>
3.1	Компьютер, тоног төхөөрөмж	2013	406.0	406.0
3.2	Тавилга, эд хогшил	2013	307.3	307.3
3.3	Автомашин	2013	340.0	340.0
3.4	Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын тоног төхөөрөмж	2012-2013	28.8	17.3
3.5	Харуул хамгаалалтын камер дохиоллын системд холбогдох, ажилчдын цаг бүртгэдэг машин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам хийлгэх, цахилгаан үүсгүүр худалдан авах /Баян-Өлгий, Өмнөговь, Төв,Багануур/	2013	18.5	18.5
3.6	Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний дараалал зохицуулах болон ажилтнуудын үнэлгээний төхөөрөмж /Улаанбаатар/	2012-2013	160.0	80.0
<b>4</b>	<b>Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл</b>		<b>83.8</b>	<b>83.8</b>
4.1	Барилгын зураг төсвийн үнэ /Архангай, Говь-Алтай, Өмнөговь, Ховд, Баянгол, Баянзүрх, Багахангай, Нийгмийн даатгалын ерөнхий газар/	2013	83.8	83.8

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

**ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН  
2013 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Хүний хөгжил санд 2013 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, тус сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээ, эрсдэлийн нөөц хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалтыг тогтоох, зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.



**2 дугаар зүйл.Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль тогтоомж**

2.1.Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай<sup>1</sup>, Төсвийн тогтвортой байдлын тухай<sup>2</sup>, Хүний хөгжил сангийн тухай хууль<sup>3</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2013 ОНЫ ТӨСВИЙН  
ОРЛОГО, ЗАРЛАГА, ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР,  
ЭРСДЭЛИЙН НӨӨЦ ХӨРӨНГӨ**

**3 дугаар зүйл.**Хүний хөгжил сангийн төсөвт 2013 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 621,368.7 сая төгрөгөөр, төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөг/
1	Сангийн сайд	396,455.2
	1.1.Татварын ерөнхий газар	396,455.2
	1.1.1.Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.2-т заасан орлого	396,455.2
2	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд	70,000.0
	2.1.Төрийн өмчийн хороо	70,000.0
	2.1.1.Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-д заасан орлого	70,000.0
3	Уул уурхайн сайд	154,913.5
	3.1.Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.2-т заасан орлого	154,913.5

**4 дүгээр зүйл.**Хүний хөгжил сангийн төсвөөс 2013 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 284,151.5 сая төгрөгөөр баталж, төсвийн ерөнхийлөн захирагч нарт дор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөг/
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	284,151.5
	1.1.Төр хариуцан төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэл	12,151.5
	1.2.Иргэдэд олгох бэлэн мөнгө	272,000.0

<sup>1</sup>Төсвийн тухай хууль-“Төрийн мэдээлэл”эмхтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Төсвийн тогтвортой байдлын тухай хууль-“Төрийн мэдээлэл”эмхтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Хүний хөгжил сангийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2009 оны 45 дугаарт нийтлэгдсэн.



2	Сангийн сайд	287,422.2
	2.1.Урьдчилгаа мөнгө, зээлийн үндсэн төлбөрт	95,300.0
	2.2.Засгийн газрын дотоод зээлийн үндсэн төлбөрт	192,122.2
	2.3.Эрсдэлийн нөөц хөрөнгө	0.0

**5 дугаар зүйл.** Хүний хөгжил санд 2013 оны төсвийн жилд хуримтлуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг 49,795.0 сая төгрөгөөр баталсугай.

### ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 11 дүгээр  
сарын 08-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХАМААРУУЛАХГҮЙ БАЙХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан 2013 онд хэрэгжүүлэх шинэчлэлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах 50.0 тэрбум төгрөгийг Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусган батлахад Төсвийн тухай хуулийн 22.6.4 дэх заалт, 29.4 дэх хэсэг, 33.2.6 дахь заалтыг тус тус хамааруулахгүй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хөрөнгийг 2013 оны төсвийн хөрөнгө оруулалтын дүнд багтаан, төсвийн нийт хөрөнгө оруулалтын 5 хувиас хэтрэхгүй байхаар Ерөнхий сайдын төсвийн багцад нэгдсэн дүнгээр нь зориулалт, чиглэлийг заасан жагсаалтаар тусгана.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо 2013 оны 1 дүгээр улиралд багтаан төсөл, арга хэмжээ бүрээр төсөвт өртөг, санхүүжилтийн хэмжээг батална.



**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 11 дүгээр  
сарын 08-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

**Улсын Их Хурлын гишүүнээс  
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3 дахь заалт, 6.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Ухнаагийн Хүрэлсүхийг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 11 дүгээр  
сарын 08-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар  
хот

**Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн  
бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Цэрэнхүүгийн Шаравдоржийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 11 дүгээр  
сарын 08-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар  
хот

### **Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бямбадоржийн Болдбаатарыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсугай.

2.Энэ тогтоолыг 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 11 дүгээр  
сарын 08-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар  
хот

### **“Чингис хаан” одон бий болгох тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Чингис хаан” одон бий болгох тухай” Улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоолд дор дурдсан агуулгатай 3, 4 дэх заалт нэмсүгэй:

“3.“Чингис хаан” одонг Их Эзэн Чингис хааны өдөр буюу Их Эзэн Чингис хаан мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар олгож байсугай.

4.“Чингис хаан” одонд нэр дэвшүүлэх, шагнах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосугай.”

2.“Чингис хаан” одон бий болгох тухай” Улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.



3.Энэ тогтоолыг 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 11 дүгээр  
сарын 08-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар  
хот

**Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд  
баримтлах үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанкны/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор макро зохистой бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэн санхүүгийн салбарын байдлыг улирал бүр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

3.Иргэдийн өргөн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах үр дүнтэй арга хэмжээ авч, үнийг тогтворжуулах цогц механизм боловсруулж хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/-нд даалгасугай.

4.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай болон бусад шаардлагатай хууль тогтоомжийг олон улсын холбогдох стандартад нийцүүлж, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /ФАТФ/-аас тогтоосон Монгол Улсын үнэлгээг дээшлүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/-нд даалгасугай.

5.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг баталж, тогтоолыг хэрэгжүүлэх ажлын явц байдлын талаар улирал бүр Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж ажиллахыг Монголбанк /Н.Золжаргал/-нд даалгасугай.



6.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

7.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Б.Гарамгайбаатар/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2012 оны  
57 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР  
2013 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөл болсон макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд мөнгөний бодлогыг чиглүүлнэ.

**1.Макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:**

1.1.Мөнгөний бодлогын арга хэрэгслээр инфляцийг тогтвортой нам түвшинд байлгаж, Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг хязгаарлах бодлого баримтална. Үүний үр дүнд хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2013 оны эцэст 8 хувиас хэтрүүлэхгүй байлгаж, улмаар 2014-2015 онд инфляцийг 5-7 хувийн түвшинд байлгах нөхцөл бүрдүүлнэ.

1.2.Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримтална.

1.3.Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах, нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын үндсэн зорилтын хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах замаар Төв банкны хариуцлагыг сайжруулна.

**2.Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:**

2.1.Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг нэмэгдүүлэн салбарын эрсдэл даах чадварыг дээшлүүлнэ.

2.2.Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны



онцлогтой уялдуулан эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.

2.3.Зээлийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, улмаар зээлийн хүү буурах нөхцөл бүрдүүлэх зорилгоор барьцаа хөрөнгийн эрх зүйн орчныг шинэчилнэ.

**3.Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:**

3.1.Төрөөс мөнгөн хадгаламжид гаргах баталгааг хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоонд шилжүүлснээр төрд учрах эрсдэлийг бууруулж, банкны салбарын санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлнэ.

3.2.Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөр тооцооны системийн шинэчлэлийг 2013-2015 онд эрчимжүүлэх ажлын хүрээнд бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, боловсронгуй болгоно.

3.3.Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг үнэлэх олон улсын жишигт суурилсан аргачлалыг нэвтрүүлж эхэлнэ. Банк, санхүүгийн үйлчилгээг иргэдэд жигд хүртээмжтэй болгох, иргэдийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана.

3.4.Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох, тэдгээрийг хөрөнгөөр баталгаажсан, Засгийн газрын болон орон нутгийн үнэт цаасны зах зээлд оруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.5.Алт цэвэршүүлэлтэд олон улсын стандартыг нэвтрүүлэх чиглэлээр Засгийн газартай хамтран ажиллана.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 11 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар 58

Улаанбаатар  
хот

**Бүгд Найрамдах Кени Улстай  
дипломат харилцаа тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүгд Найрамдах Кени Улстай дипломат харилцаа тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 11 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар 59

Улаанбаатар  
хот

### **Сонгуулийн зарим зардал санхүүжүүлэх тухай**

Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал 2,283.4 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2012 оны төсвийн багцад туссан Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх зориулалт бүхий зардлын үлдэгдлээс санхүүжүүлэхийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга /Ч.Содномцэрэн/-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан хөрөнгийг Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д заасан зориулалтаар зарцуулж, тайлагнахыг Сонгуулийн ерөнхий хороо /Ч.Содномцэрэн/-нд даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2012 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 11 дүгээр  
сарын 08-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын 2013 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.17 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай:

1/Монгол Улсын 2013 оны төсвийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд бүхий л нөөц, бололцоогоо дайчлах, төлөвлөгөөний зорилтыг нэр, төрөл бүрээр нь хангаж биелүүлэх ажлыг шуурхай, оновчтой зохион байгуулах;

2/Төсвийн тухай хуульд орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэхээр заасан эх үүсвэрийн тодорхой хэсгийг бусад хуульд тусгай зориулалтын санд төвлөрүүлэхээр заасан нь хууль хоорондын зөрчил бий болгож байгааг өөрчлөх, Засгийн газрын тусгай зориулалтын сангуудын үйл ажиллагаа, зориулалтыг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж 2013 оны 2 дугаар сард багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг Улсын Их Хурал баталж байхаар Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, 2012 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4/энэ тогтоолын 1 дэх заалтын 3 дахь дэд заалтад заасан Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийг боловсруулж, 2013 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөв, үнэ бүрдлийн механизм, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, норм, норматив, стандартыг шинэчлэн, орон нутагт баригдах орон сууц, цэцэрлэг, сургуулийн дотуур байрыг нэг хэв маягийн зураг, төсөв гарган мөрдүүлэх;

6/Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэн, батлах явцад түүнд тусгагдаагүй үлдсэн эрүүл мэнд, боловсролын салбарт зайлшгүй шаардагдах хөрөнгө оруулалтын арга хэмжээг бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх, эсхүл төсвийн тодотголд тусгуулан, хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: [turiin\\_medecelel@parliament.mn](mailto:turiin_medecelel@parliament.mn)

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 5.5

Индекс: 14003